


# Хүүхдэд зориулсан Библи танилцуулж байна

## Иошуа эрхийг авсан нь



Зохиогч: Edward Hughes  
Зураглаач: Janie Forest

Орчуулсан: Damdin Horolsuren  
Найруулсан: Ruth Klassen

Түүх 13/60

[www.M1914.org](http://www.M1914.org)

*Bible for Children, PO Box 3, Winnipeg, MB R3C 2G1 Canada*

Зөвшөөрөл: Та энэ бүтээлийг хувилах хуулах эрхтэй харин худалдахыг хориглоно.


Монгол хэл

Mongolian

Моcе нас эцэслэв. Иошуа Бурхан түүнийг Израилийг удирдуулахаар сонгосон гэдгийг мэдэж байв. Иошуа цэргээ бэлдэхээсээ өмнө өөрийгөө бэлдэж байлаа. Бурхан Иошуд ялалтыг өгөх болно гээд хэрэв ард түмэн Бурханы үгийн дагуу байвал Бурхан өөрийн амласан газраа тэдэнд өгөх болно гэв.



Тэгээд Израильчууд Бурханыг үгэнд дуулгавартай байж Иошуаг дагах болно гэж тангараглажээ.



Шинэ удирдагч мэргэн санаа олж Канаан нутгыг судлаад Иерохо хотын хамгаалалтыг шалгаад ир хэмээн туршуулуудыг явуулжээ. Израильчууд анх тэнд тулалдсан юм.

2



Иерохогийн хаанд хотод туршуул орж ирэв хэмээн хэл хүрчээ. Хаан туршуулуудыг олуулахаар цэргээ илгээв. Тэд хайсаар Рахабын гэрт ирсэн бөгөөд тэнд туршуулууд үнэхээр байсан юм. Цэргүүд гэрийг үүдийг тогшив. Рахаб хурдан гэгч нь маалинга доогуур тэднийг нуув.


3

Цэргүүдийг явсны дараа Рахаб олсоор тэднийг доош буулган хотоос гаргав. Яагаад энэ эмэгтэй туршуулуудад тусалсан бол? Яагаад гэвэл Бурхан тэдэнтэй хамт байгааг тэр мэдсэн юм. Тэр эмэгтэй Бурхан түүнийг аврахыг хүссэн юм. Туршуулууд Рахаб болон түүний гэр бүлийг аврахаа амлажээ.



4

Бурханы амласан канаан нутаг уруу явахын тулд Иерохо орохын өмнө Израильчууд Иордан голыг гатлах хэрэг гарав. Гэвч тэнд ямар ч гүүр байсангүй! Хүмүүс голыг хэрхэн гаталсан бол?




5

Бурхан Иошуд хандан ард түмэн болон цэргүүдийг тахилч нар дагуулах ёстой бөгөөд тэд арван хууль хийсэн гэрээний авдрыг гартаа дамнан авч явах ёстой гэв. Тахилч нар голын эрэгт ирэхэд Бурхан гайхамшгийг үйлдэв. Бурхан гол дундуур хуурай замыг гаргав.



6

Ийнхүү бүх хүмүүс аюулгүй гарсны дараа тэд арван хоёр том чулууг голд тавиад бас өөр арван хоёр чулууг Канаан голын эрэг дээр байрлуулав. Эдгээр нь ард түмэн хүүхдүүддээ Бурханы агуу хүч болон хайрыг гэрчлэх дурсгал болон үлджээ.




7



Иерохо хот эргэн тойрон маш баг бөх хэрэмээр хүрээлгдсэн байлаа. Дайралт Иошуагийн төлөвлөсөнөөр болсон бөгөөд Бурхан өөрийн ард түмний төлөө ялалтыг өгсөн гэдгийг Израилийн шинэ удирдагчид мэдүүлэхийн тулд Бурхан өөрийн армийг тэнгэрээс илгээв.


8



Бурхан Иошуад хэрхэн Иерохог дайрахыг зааж өгөв. Энэ нь маш хачирхалтай төлөвлөгөө байлаа. Бурханы ард түмэн хотын гадна талаар тойрон алхах бөгөөд ингэхдээ зургаан өдрийн турш өдөрт нэг удаа тойрон алхана харин долоо дахь өдөр долоон удаа тойрч алх. Тэгээд тэд бүрээ үлээн хашхирах ёстой, ингэвэл хотын хана нуран унана! гэлээ.

9

Иошуа болон түүний цэргүүд Бурханы тушааснаар хийв. Магадгүй Иерохо хотын хүмүүс тэднийг хараад шоолон инээж байсан байх. Харин тэд долоон өдөр хэрмийг тойрч алхсаны дараа



тахилч нар хуцын эврэн бүрээ үлээхэд ард түмэн хашхирав. Энэ үед Бурханы амлалт биелэв ...

ИЕРОХОГИЙН АГУУ  
ХЭРМЭН ХАНА  
БУТРАН  
УНАВ!

7



10



Тэр хотоос зөвхөн Рахабын гэр бүл аврагдав. Тэр эмэгтэй цонхноосоо час улаан өнгийн тууз зүүжээ. Иошуагийн хүмүүс туузыг хараад Рахаб болон түүний гэр бүлийг хотоос авч гарав. Тэгээд Иерохо хот Бурханы тушааснаар устгагдав.

11



Иошуа хотын алт, мөнгө, эрдэнэсийг Бурханы үйлчлэлд хэрэглэв. Тэгээд тэр энэ нүгэлт хотыг дахин босгох хэн болов ч хараагдсан гэв. Удалгүй Канаан нутгийн хүмүүс Иерохо хот Иошуад хэрхэн ялагдсан тухай сонсов. Тэд Бурхан тэр ард түмэнтэй хамт байгааг ойлгов.

12

Иошуа эрхийг авсан нь

Бурханы үг Библиээс авсан түүх

Иошуа 1-6

"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг."

Дуулал 119:130



Бурхны гэм гэж нэрлэдэг муу зүйлийг бид хийдгийг Бурхан сайн мэднэ. Гэмийн шийтгэл нь үхэл юм.

Бурхан бидэнд маш их хайртай Тэрээр өөрийн хүү Есүсийг бидний гэмийн төлөөс болгон загалмайн үхэлд тушаасан. Есүс дахин амилж мөнхийн улсдаа буцсан! Одоо Бурхан бидний гэмийг уучилж чадна.

Хэрвээ та гэмээсээ эргэхийг хүсвэл, Бурханд хандан ийнхүү хэлээрэй: Бурхан минь ээ, Би Есүс миний төлөө үхээд дахин амилсан гэдэгт итгэж байна. Миний амьдралд орж ирээд миний гэмийг уучлаач тэгээд би шинэ амьдралаар амьдарч дараа нь тантай хамт мөнхөд амьдрах болно.

Таны хүүхэд шиг Таны төлөө амьдрахад туслаач.

Амен Иохан 3:16

Библи уншиж өдөр бүр Бурхантай ярилцаарай!